



I-V/2021


Тархаасан: 2021 оны 6 дугаар сарын 14



Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн 169 бүтээлд патент олгожээ.

Оюуны өмчийн газрын мэдээллээр улсын хэмжээнд 2021 оны эхний 5 сард шинэ бүтээл болон бүтээгдэхүүний загварын патент авахаар 217 иргэн, хуулийн этгээд мэдүүлэг гаргасан нь өмнөх оны мөн үеэс 39 (21.9%)-өөр өсжээ.

Зураг 1. Патент, жил бүрийн эхний 5 сард




Тайлбар: Оюуны өмчийн патентын мэдүүлгийн анхдагч огнооноос хойш 9 сарын дотор шүүлтийн дүгнэлтийг үндэслэн патент олгох эсэх талаар шийдвэр гаргадаг тул тухайн сард олгосон патент нь патентын мэдүүлгээс их байж болно.

Иргэн, хуулийн этгээдээс 2021 оны эхний 5 сард ирүүлсэн 169 бүтээлд патент олгосны 74 нь шинэ бүтээлийнх, 95 нь бүтээгдэхүүний загварынх байгаа нь өмнөх оны мөн үеэс шинэ бүтээлийн патент 36 (94.7%)-гаар өссөн, харин бүтээгдэхүүний загварын патент өмнөх оны мөн үетэй ижил байна.

Харин өмнөх сараас шинэ бүтээлийн патент 7 (87.5%)-гоор, бүтээгдэхүүний загварын патент 2 (8.7%)-оор өссөн байна.

Зураг 2. Олгосон нийт патент, төрлөөр, сараар



Зураг 3. Шинэ бүтээлд олгосон патент, олон улсын ангиллаар, 2021 оны эхний 5 сард



Шинэ бүтээлд олгосон патент (давхардсан тоогоор)-ыг олон улсын ангиллаар авч үзэхэд 28 нь хүний хэрэгцээг хангах зүйл, 26 нь хими, төмөрлөг, 12 нь механик инженер, гэрэлтүүлэг, халаалт, зэвсэг, тэсрэх бодис, 11 нь физик, 11 нь технологийн төрөл бүрийн арга ажиллагаа, тээвэрлэлт, 13 нь бусад ангилалд хамаарч байна.

Хүснэгт 1. Ашигтай загвар, жил бүрийн эхний 5 сард

Үзүүлэлт	2020		2021	
	V	I-V	V	I-V
Ашигтай загварын нийт мэдүүлэг	23	127	12	96
Дотоодын мэдүүлэг	23	125	11	94
Гадаадын мэдүүлэг	-	2	1	2
Гэрчилгээ олгосон ашигтай загвар	22	98	6	57
Гэрчилгээ олгохоос татгалзсан	3	12	-	25
Ашигтай загварын бүртгэлд оруулсан нэмэлт, өөрчлөлт	5	8	-	-

Оюуны өмчийн байгууллагад ашигтай загварын гэрчилгээ авахаар 2021 оны эхний 5 сард 96 иргэн, хуулийн этгээд мэдүүлэг гаргасан нь өмнөх оны мөн үеэс 31 (24.4%)-ээр буурчээ. Мөн иргэн, хуулийн этгээдийн ирүүлсэн 57 ашигтай загварт гэрчилгээ олгосон нь өмнөх оны мөн үеэс 41 (41.8%)-ээр, өмнөх сараас 10 (62.5%)-аар буурсан байна.

Хүснэгт 2. Барааны тэмдэг, жил бүрийн эхний 5 сард

Үзүүлэлт	2020		2021	
	V	I-V	V	I-V
Барааны тэмдгийн нийт мэдүүлэг	330	1 789	545	1 953
Дотоодын мэдүүлэг	199	751	242	990
Гадаадын мэдүүлэг	38	158	49	225
Олон улсын мэдүүлэг ¹	93	880	254	738
Эрхийн хамгаалалт олгосон нийт барааны тэмдэг	362	1 834	316	1 525
Бүртгэхээс татгалзсан	172	820	143	761
Барааны тэмдгийн бүртгэлд оруулсан нэмэлт, өөрчлөлт	56	406	134	485

Монгол Улсын хэмжээнд 2021 оны эхний 5 сард барааны тэмдгийн эрхийн хамгаалалт авахаар 1953 иргэн, хуулийн этгээд мэдүүлэг гаргасан байна. Нийт мэдүүлсэн барааны тэмдгийн 738 (37.8%) нь Мадридын хэлэлцээрийн дагуу Монгол Улсыг нэр зааж гаргасан олон улсын мэдүүлэг байна. Мөн иргэн, хуулийн этгээдийн ирүүлсэн 1525 барааны тэмдэгт эрхийн хамгаалалт олгосон нь өмнөх оны мөн үеэс 309 (16.8%)-өөр буурч, 761 барааны тэмдгийг бүртгэхээс татгалзсан байна.

Тайлбар: ¹ Барааны тэмдгийн эрхийн хамгаалалт авахаар Мадридын хэлэлцээр болон Протоколын дагуу мэдүүлсэн Монгол Улсыг нэр зааж гаргасан олон улсын мэдүүлэг юм.

2021 оны эхний 5 сард бүтээлээ зохиогчийн эрхээр хамгаалуулахаар мэдүүлэг гаргасан 500 иргэн, хуулийн этгээдийн бүх бүтээлд шинээр зохиогчийн эрхийн гэрчилгээ олгожээ. Энэ нь өмнөх оны мөн үеэс 31 (5.8%)-ээр буурчээ.

Хүснэгт 3. Зохиогчийн эрхийн мэдүүлэг, бүтээлийн төрлөөр, дүнд эзлэх хувиар, 2021 оны эхний 5 сард

Зохиогчийн эрхийн бүтээлийн төрөл	Зохиогчийн эрхийн мэдүүлгийн тоо	Дүнд эзлэх хувь
Шинжлэх ухаан, утга зохиолын бичмэл буюу аман төрөлд хамаарах бүтээл, түүнчлэн компьютерын программ	247	49.4
Материалыг нь сонгон түүвэрлэх, байршуулах зэргээр бүтээлч хөдөлмөрийн үр дүнд бий болсон, өөрийн бүтэц агуулгаараа оюуны бүтээлд тооцогдох тайлбар толь, лавлах, зохиолын цоморлог, өгөгдөхүүн-мэдээллийн сангийн бусад эмхэтгэлүүдийн төрөлд хамаарах бүтээл	100	20.0
Дүрслэх урлагийн төрөлд хамаарах бүтээл	50	10.0
Хөгжмийн урлагийн үгтэй болон үггүй бүтээл	38	7.6
Дуу авиа бүхий дүрст бүтээл /телевизийн нэвтрүүлэг, кино урлагийн бүтээл/	26	5.2
Архитектурын бүтээл, уран баримал, уран барилгын төрөлд хамаарах бүтээл	18	3.6
Үүсмэл бүтээлийн төрөлд хамаарах бүтээл	12	2.4
Ардын урлагийн бүтээлд тулгуурлан түүрвисан үүсмэл бүтээлийн төрөлд хамаарах бүтээл	7	1.4
Гэрэл зургийн болон түүнтэй төсөөтэй аргаар түүрвисан бүтээл	1	0.2
Чимэглэх болон хавсарга урлаг, тайз чимэглэлийн төрөлд хамаарах бүтээл	1	0.2
Нийт дүн	500	100.0

Ойлголт, тодорхойлолт:

Оюуны өмч: Оюуны бүтээлч үйл ажиллагааны үр дүнд бий болсон зохиогчийн эрхийн бүтээл, зохиогчийн эрхэд хамаарах эрхийн объект болон аж үйлдвэрийн өмчийг ойлгоно. Оюуны өмчийг хоёр хэсэгт ангилна. Үүнд:

- Аж үйлдвэрийн өмч: Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар, барааны тэмдэг, газар зүйн заалт хамаарна;
- Зохиогчийн эрх: Зохиогчийн эрхийн бүтээлд ном, хөгжим, уран зураг, уран баримал, кино, компьютерийн программ, мэдээллийн сан, зар сурталчилгаа, газрын зураг, техникийн зураг зэрэг бүтээл багтдаг.

Патент: Тодорхой зүйлийг хийх шинэ арга замыг гаргасан эсвэл аливаа техникийн шинэ шийдлийг санал болгож буй бүтээгдэхүүн болон арга ажиллагаанд (шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварт) өгч буй онцгой эрх юм.

Шинэ бүтээл: Байгалийн хуульд тулгуурлан сэдэж, үндэслэлийг нь тодорхойлсон, үйлдвэрлэх арга ажиллагаа болон бүтээгдэхүүнд хамаарах, шинэ бүтээлийн түвшин агуулсан шинэ шийдлийг ойлгоно.

Бүтээгдэхүүний загвар: Бүтээгдэхүүний гадаад хэлбэр, хийцэд хамаарах гоёл чимэглэл, өнгө, өнгөний хослол агуулсан, шинээр зохион бүтээсэн, өвөрмөц шийдлийг ойлгоно.

Ашигтай загвар: Үйлдвэрлэлийн багаж, хэрэгсэл, аргад хамаарах, үйлдвэрлэлд ашиглах боломжтой техникийн шинэ шийдлийг ойлгоно.

Барааны тэмдэг: Иргэн, хуулийн этгээд өөрийн бараа, үйлчилгээг бусад этгээдийн бараа, үйлчилгээнээс ялгах зорилгоор хэрэглэх ялгагдах чадвартай илэрхийллийг ойлгоно.

Газар зүйн заалт: Тухайн газар нутгийн байгаль, цаг уурын нөхцөл, эсхүл тухайн газар нутгийн хүмүүсийн дадал заншил зэрэг хүчин зүйлээр тодорхойлогдсон чанар, нэр хүнд, бусад онцлог шинж чанар бүхий бараа, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн улс, бүс, газар нутгийн газар зүйн тодорхойлолтыг ойлгоно.

Эх үүсвэр: Оюуны өмчийн газар

Ангилал, код: Патентын олон улсын ангилал (PCT), Ниццийн ангилал (NCL), Локарногийн ангилал (LOC)



Мэдээлэл авах линк:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь: 2021 оны 7 дугаар сарын 12

*Хүн ам, нийгмийн статистикийн
газрын дарга А.Амарбал
Утас: (976-51)-264805*

*Хүн ам, нийгмийн статистикийн
газрын статистикч А.Дуламжав
Утас: (976-51)-263966*

